



# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)

globe <http://rtcc.mrtd.gov.mn>

envelope [info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)

phone [+976 77244409](tel:+97677244409)

## ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

2018 оны 6-р сарын дугаар

NEWS

Төмөр замын нийтлэг багц дүрмийг захиргааны хуульд нийцүүлэн өөрчлөх ажлын хэсэгт төвийн мэргэжилтнүүд ажиллаж байна

Зам, тээврийн хөгжлийн сайдын 13-р тушаалаар байгуулагдсан III ажлын хэсгийн хүрээнд Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмын төсөл, саналын товъёо, тайлан танилцуулга, байгууллагуудын санал зэргийг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-д хүлээлгэн өглөө. Мөн төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмын маягтуудыг ҮСХ-оос өгсөн маягтын загвар, стандартын дагуу боловсруулан дуусгаж, ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 144 тоот албан бичгээр хүргүүлж ЗТХЯ-ны Төмөр замын асуудал эрхэлсэн Төмөр замын тээврийн хяналт шинжилгээ хариуцсан байцаагч нар болон ЗТХЯ-ны Төмөр замын тээвэр зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтнүүдтэй хамтран шинэчлэн боловсруулж буй ТЗБХМС журманд нэмэлтээр орох маягтыг дахин боловсрууллаа.

NEWS

Аж ахуйн нэгжүүдийн хөдлөх бүрэлдэхүүний гүйлтийг программ хангамжид үе шаттайгаар оруулахаар хамтран ажиллаж байна

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн программ хангамжид ХШҮДАГ-ын өгсөн зөвлөмжийн дагуу хөдлөх бүрэлдэхүүний гүйлтийг тооцоолох хэсгийг тусгах “Эн Жи Ай электроникс” ХХК-тай хамтран ажиллаж байна. “БТЕГ” ХХК-ний хөдлөх бүрэлдэхүүний гүйлтийг тооцоолох хэсгийг программ дээрээс хардаг болсон ба бусад аж ахуйн нэгжүүдийн хөдлөх бүрэлдэхүүний гүйлтийг үе шаттайгаар программ хангамжид оруулахаар ажиллаж байна.

NEWS

ЗТХЯ-ны 08/2405 тоот албан бичгээр ирсэн “Галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн төлөвлөрүүлэлт ба диспетчерийн хяналтын систем” стандартын төсөл, “Төмөр замын техникийн найдвартай байдал, ерөнхий ойлголт тодорхойлолт” стандартын орчуулгын төсөлд санал боловсрууллаа.

NEWS

Сайдын 13-р тушаалаар байгуулагдсан II ажлын хэсгийн хүрээнд Дохиолол холбооны журмын төсөлд холбооны заалт нэмүүлэхээр “УБТЗ” ХНН-ийн Дохиолол, холбоо, сүлжээ, эрчим хүчний албаны холбогдох ажилтнуудтай уулзаж санал хэлэлцлээ.

NEWS

“ГТХЗНТ” УТҮГ-ын ТЭЗҮ, Урьдчилсан ТЭЗҮ-с, ТИА-942 стандарт зэрэг материалуудыг цуглуулан, техникийн шийдлийг сайжруулан боловсруулж, зөвлөмж гаргахаар ажиллаж байна.

NEWS

Төвийн захирлын 2018.06.11-ний А/38 дугаар тушаалаар байгуулагдсан “Мэдээлэл холбооны сүлжээний давхардлыг арилгах тухай” Засгийн газрын 6 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Япон улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр байгуулсан шилэн кабелийн өмчлөлийг төрийн мэдэлд шилжүүлэх асуудлыг судалж, дүгнэлт, санал гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт төвийн мэргэжилтнүүд ажиллалаа.

# ХОС ЗАМ

## СУРГАЛТЫН ТӨВ

“Хос зам” сургалтын төвд “Төмөр замын замчин” мэргэжлийн анги төлөвлөгөөний дагуу 2018.06.04-19-ны хооронд “Замчны хөдөлмөрийн аюулгүй байдал”, “Замын бүтэц”, “Төмөр замын хиймэл төхөөрөмж, байгууламж”, “Төмөр замын замын ажлын технологи”, “Төмөр замын ерөнхий зохион байгуулалт”, “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”, “Дохиоллын журам”, “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам” зэрэг нийт 74 цагийн 8 төрлийн мэргэжлийн хичээлүүдийг танхимын сургалтаар орлоо. Танилцах дадлагаар төвийн ХЗХБХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Бат-Оргил суралцагч нарыг удирдан “УБТЗ” ХНН-ийн Зүтгүүрийн депогийн үйл ажиллагаа, зохион байгуулалт болон хөдлөх бүрэлдэхүүний түүхэн музейтай танилцсан юм.



Төмөр замын тээврийн 2018 оны 5-р сарын статистик мэдээ

### Зорчигч тээвэрлэлт

**2017 V сар** 211 мян.зор

**2018 V сар** 207.6 мян.зор

10% өсөлт өөр өөр өдөр  
2018 V сар 207.6 мян.зор  
2018 IV сар 103.6 мян.зор

### Ачаа тээвэрлэлт

**2018 V сар** 2131.6 мян.тонн

**2018 I-V сар** 10258.2 мян.тонн

890.2 мян.тн  
817 мян.тн  
327.2 мян.тн  
288.2 мян.тн

### Ачаа ачилт

2018 V сар 13152  
2018 IV сар 70642

АЧИЛТ-АЧААНЫ ТӨРЛӨӨР 2018 V

Ачаа ачилт 2018 оны I-V сарын өмнөх жилтэй харьцуулахад 24.9 сая. тонн өсөлт үзүүлж, өсөн үрэлжлэлтэй байна.

### Зорчигч эргэлт

**2017 V сар** 80 сая.зор-км

**2018 V сар** 82.4 сая.зор-км

1.6% өсөлт өөр өөр өдөр

### Ачаа эргэлт

**2018 V сар** 1300.6 мян.тн-км

**2018 I-V сар** 6022.7 мян.тн-км

Өсөлт өөр өөр өдөр 0.7%

### Дамжин өнгөрсөн ачаа

Дамжин өнгөрсөн ачаа (тонн)

Дамжин өнгөрсөн ачаа 2018 оны V сарын өмнөх жилтэй харьцуулахад 21.6 сая. тонн өсөлт үзүүлжлэлтэй байна.

2017 IV сар 115808.2 мян.тн-км  
2018 IV сар 140008.5 мян.тн-км

### Галт тээврийн зурмагийн биелэлт

Зурмагийн биелэлт 82.1% төлөвлөгөөний 82.1% өөрчлөлт 19.8% өсөлт, өмнөх жилтэй харьцуулахад 30.0% төлөвлөгөөний 82.0% өөрчлөлт 18.7% өсөлт, амьжиргалт зурмагийн биелэлт 83.0% төлөвлөгөөний 83.0% өөрчлөлт 17.2% өсөлт, өмнөх жилтэй харьцуулахад 30.0% өөрчлөлт 18.8% өсөлт, амьжиргалт зурмагийн биелэлт 82.8% байна.

### Галт тээврийн зурмагийн биелэлт

Нийт тээврийн 0.1% төлөвлөгөөний 82.1% төлөвлөгөөний 82.1% өөрчлөлт 19.8% өсөлт, өмнөх жилтэй харьцуулахад 30.0% төлөвлөгөөний 82.0% өөрчлөлт 18.7% өсөлт, амьжиргалт зурмагийн биелэлт 83.0% төлөвлөгөөний 83.0% өөрчлөлт 17.2% өсөлт, өмнөх жилтэй харьцуулахад 30.0% өөрчлөлт 18.8% өсөлт, амьжиргалт зурмагийн биелэлт 82.8% байна.

### Тээвэрлэсэн ачаа (сүүрэг, бүтэц, замшигтай)

Төвийн бүс 12.92 мян.тн-км  
Төвийн бүс 218.84 мян.тн-км  
Төвийн бүс 0.0 мян.тн-км

NEWS

Төвийн 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

2018 оны төсвийн ерөнхийлөн захирагчтай хийсэн гэрээний хагас жилийн тайлангаар үр дүнгийн гэрээний 47, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 26, сайдын тушаалын 31, сайдын шуурхай хуралдааны 2, захирлын тушаалын 91, туслах чанараар баталсан төлөвлөгөөний 42, нийт 494 арга хэмжээний хэрэгжилт 84.52 хувьтай байгаа бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай удирдлагууд танилцлаа. Үүнээс гадна үр дүнгийн гэрээний хэрэгжилт 76.66, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 76.66, сайдын тушаалын хэрэгжилт 76.19, сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгаврын биелэлт 100, нэгжүүдийн төлөвлөгөөний хэрэгжилт 88.79, захирлын тушаалын хэрэгжилт 72.93, туслах чанараар баталсан төлөвлөгөөний хэрэгжилт 84 хувьтай гарсан байна.

NEWS

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдлыг ЗТХЯ-нд цаг тухай бүр нь танилцуулж байна

Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн байдал, сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдлыг ЗТХЯ-ны ХШҮДАГ-т цаг тухай бүр нь тайлагнаж байна. Мөн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан, илтгэх хуудсыг ЗТХЯ-нд хүргүүлж төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан, илтгэх хуудсыг 153 дугаартай албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүллээ.

NEWS

Шилэн дансны мэдээллийн <https://info.shilendans.gov.mn/form/datalist/4> цахим хуудсанд 2018.06.14-ний 17:16, 2018.06.19-ний 11:08 цагт хандах эрхээр нэвтэрч ҮИ сард тухай бүр оруулах 8 мэдээлэл, бүтэн бүтэн жилээр оруулах 1 мэдээллийн “Мэдээлэл оруулах хугацаа болсон”-нд хяналт тавьж ажиллалаа.

NEWS

Хууль зүйн сайдын 2016 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу “Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам”-ын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, ЗТХ-ийн сайдын “Журам батлах тухай” тушаалын төслийг 2 хувилбараар шинэчлэн боловсрууллаа.

NEWS

Зам, тээврийн хөгжлийн яамны хэлтсийн дарга Д.Жавхлан төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журмын төсөлтэй танилцаж, редакц хийсэнтэй холбогдуулан төслийн засвар, өөрчлөлтийг хийж журмын төсөлтэй холбоотой баримт бичгийг файл хэлбэрээр ЗТХЯ-нд хүргүүллээ.



Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна


Төмөр замын болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагуудын хоногийн болон сарын статистик мэдээг салбарын мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байна. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлтийн мэдээ
- Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ /өссөн дүнгээр/
- Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/
- Дамжин өнгөрөх ачааны мэдээ /чиглэл, зуучлагч, төрлөөр, өссөн дүнгээр/
- Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ /чиглэл, зуучлагчаар, өссөн дүнгээр/
- Зорчигч тээвэрлэлтийн мэдээ
- Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын мэдээнүүд багтаж байна.



Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлүүдийн 6-р сарын дугааруудыг байршууллаа

2018 оны зургаадугаар сард Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлийн 6-р сарын дугааруудыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн [www.rtcc.mrtd.gov.mn](http://www.rtcc.mrtd.gov.mn) цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэлээ.





## Суурь бүтцийн 2018 оны 6-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын тайлан

2018 оны 6-р сард нийт 187 тасалдал, 248,8 галт тэрэг цагийн барилт үүсэж, 46,66 сая төгрөгний хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:



Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 24-н нэгж буюу 14,7%, 57,6-н цаг буюу 30,1%-иар, хохирлын хэмжээ 20,27 сая төгрөг буюу 76,8%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд:



NEWS

Төвийн албан хаагчид сургалт, мэдээллийн арга хэмжээнд тогтмол хамрагдаж байна

NEWS

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Дотоод үйлдвэрлэл, төрийн худалдан авалт 2018” үзэсгэлэн, семинар, хэлэлцүүлэгт болон “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар болон баримт бичгийн стандартын тухай үндсэн ойлголтууд сэдэвт сургалтад хамрагдлаа.

NEWS

Төрийн ордонд 2018.06.19 өдөр Германы хамтын ажиллагаа болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулсан “Мэргэжлийн боловсрол, сургалт ажилсаг Монгол” зөвлөгөөнд оролцлоо.

NEWS

Авлигатай тэмцэх газраас 2018.06.07-нд зохион байгуулсан “Дотоод хяналт, аудитын нэгжийн дарга, ажилтнуудад зориулсан авлигын эсрэг сургалт”-д хамрагдлаа.



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ




“ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ -  
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАЛТ 2018”  
ҮЗЭСГЭЛЭН, СЕМИНАР, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2018 оны 06-р сарын 05 | Улаанбаатар хот







 **8-р давхар, Хан-Уул цамхаг,  
Б.Шаравын гудамж 6,  
3-р хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот 17042, Монгол Улс**

